



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/128

Улаанбаатар хот

Ажил мэргэжлийн уралдааны баг тамирчдыг  
томилж, төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Компаний захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 оны хамтын гэрээний 4.2 дахь заалт, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас ирүүлсэн 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 02/1285 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр шуурхай ажиллагааны ажиллагсдын дунд зохион байгуулагдах ажил мэргэжлийн уралдаанд оролцох баг тамирчдыг 1 дүгээр хавсралтаар, уралдааны төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Уралдаанд оролцох баг, тамирчдыг бэлтгэж, удирдлага зохион байгуулалтаар хангах, тэмцээний үр дүнг тайлагнаж ажиллахыг Техникийн бодлого төлөвлөлт, шуурхай ажиллагааны албаны дарга /Ц.Батбаатар/-д даалгасугай.
3. Дээрх уралдааны төсөв болох 830'000 /найман зуун гучин мянга/ төгрөгийг хөдөлмөр хамгааллын зардлаас тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтэст зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Гоёцэцэг/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БЯМБААХҮҮ



Tushaal.2019

360000997